

“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ

2025 ОНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Зүйл заалтын агуулга	Хэрэгжилтын тайлан	Хэрэгжил тийн хувь
1	2	3	4	5	6
УИХ-ЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ					
39	89	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-06-10 Дугаар 2025_04 ЁЗДБХ	1.1.1. 1/Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын жил бүрийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган үр дүнд хяналт тавьж ажиллах;	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
	90		1.1.3. 3/Монгол Улсын ЁС зүйн хорооны гишүүдийн, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх ЁС зүйн дэд хороодын гишүүдийн хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл, баталгааг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хангах зохицуулалт хийх.	Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолын хавсралтаар баталсан ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн А/05 тоот тушаалаар шинэчлэн баталсан. Байгууллагын “Ёс зүйн дэд хороо”-г Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/06 тоот тушаалаар байгуулан, Ёс зүйн дэд хорооны төлөвлөөг батлан, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.	
ЗГ-ЫН ТОГТООЛ					
57	122	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд	5.1 Нийслэлийн Засаг даргын тамгын газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу CMS urga dp cms Ulaanbaatar, Mongolian Baiti монгол бичгийн үсгийн фонд, орчуулгын програм албаны хэрэглээнд нэвтрүүлж edoc.ulaanbaatar.mn цахим хуудас ашиглан албан бичиг боловсруулалтыг хийн ажиллаж байна 5.3. Төрийн байгууллагын шийдвэр, албан	

1	2	3	4	5	6
			нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.	бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг эхлүүлж 2025 онд нийт 183 албан бичгийг хос бичгээр хөтөлсөн байна. 5.4. Албан хаагчдын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх талаар арга хэмжээг оруулж баталсан. 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр НЗДТГ-аас зохион байгуулагдсан “Албан хэргийг хос бичгээр хөтлөх” тухай сургалтад байгууллагын 12 албан хаагч хамрагдсан.	
62	127	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_203	1. 1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай: 1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх; 1.2. жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх; 1.3. байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах; 1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулахгүй, энэ чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх.	1.1. Тус газрын 2022 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн Б/43 тоот тушаалаар орлогч даргыг ажлаас чөлөөлсөн. 1.2. Жил бүрийн төсвийн төслийн саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалт болон урсгал зардлыг төлөвлөж, хуулийн хугацаанд НЗДТГ-т хүргүүлж ажилласан. 1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулахгүй, энэ чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулаагүй байна.	

1	2	3	4	5	6
61	104	Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 Дугаар 2024_196	3.. “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем”-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	3.1 Хүний нөөцийн цахим системд албан хаагчдын мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавин ажиллаж байна. Нийт 33 алба хаагчдын мэдээллийг бүрэн бүрдүүлсэн.	
62	106	Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-05-15 Дугаар 2024_215	4.Төрийн байгууллага хоорондоо төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад албан бичгийг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын систем (Досх)-ийг ашиглаж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй.	Тус байгууллагын Edoc системээр 33 албан бичиг ирж, 183 албан бичгийг боловсруулж холбогдох байгууллагуудад илгээсэн байна.	
67	115	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн хязгаарыг батлах тухай 2024-07-24 Дугаар 2024_10	2.Энэ тогтоолоор баталсан төсвийн хязгаарт нийцүүлэн 2025 оны төсвийн төслийг боловсруулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Тус тогтоолоор баталсан төсвийн хязгаарт нийцүүлэн 2025 оны төсвийн төслийг боловсруулан хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан байна.	
71	128	Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай 2024-10-02 Дугаар 2024_109_1	2. Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолын хавсралтаар баталсан ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн батлан хэрэгжүүлэх, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.	2. Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолын хавсралтаар баталсан ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн А/05 тоот тушаалаар шинэчлэн баталсан. Байгууллагын “Ёс зүйн дэд хороо”-г Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/06 тоот тушаалаар байгуулан, Ёс зүйн дэд хорооны төлөвлөөг батлан, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.	

1	2	3	4	5	6
99	191	Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 Дугаар 2024_196	3.. “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем”-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	3.1 Хүний нөөцийн цахим системд албан хаагчдын мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавин ажиллаж байна.Нийт 33 алба хаагчдын мэдээллийг бүрэн байршуулсан.	
117	228	Хүүхдийн эрхийг хамгаалах зарим арга хэмжээний тухай 2025-01-29 Дугаар 2025_41	2.2. Хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг таслан зогсоох арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, өвөл, хаврын улиралд зохион байгуулагдах хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээнд 18 нас хүртэлх хүүхдийг аливаа хэлбэрээр оролцуулахгүй байхад хяналт тавьж ажиллахыг бүх шатны Засаг дарга, Цагдаагийн ерөнхий газар (Т.Сүхболд), Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар (Т.Ихтамир)-т тус тус үүрэг болгосугай.	Тус байгууллагын зүгээс өвөл, хаврын улиралд хүй 7 худагт хурдан морины уралдаан, явуулахгүй байхад хяналт тавьж ажилласан.	
142	268	Зарим аймгийн баяр наадмын хугацааг тогтоох, хурдан морины шигшмэл болон бүсийн уралдааныг зохион байгуулах тухай 2025-06-04 Дугаар 2025_278	3.3. Хурдан морины 2025 оны шигшмэл “Их хурд-10” уралдааныг нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Хуй долоон худагт 2025 оны 08 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд, хурдан морины Хангайн бүсийн уралдааныг Өвөрхангай аймгийн Арвайхээр хотод 2025 оны 07 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд тус тус зохион байгуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, Өвөрхангай аймгийн Засагдарга О.Пүрэвдорж нарт даалгасугай.	2025 оны 08 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд Хурдан морины 2025 оны шигшмэл “Их хурд-10” уралдааныг Хуй долоон худагт зохион байгуулахад талбайн тохижилтын ажлыг хариуцан ажилласан.	100
143	269	Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай 2025-06-04 Дугаар 2025_279	1. 1.Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын 2025 оны 07 дугаар сарын 12, 13-ны өдрүүд нь Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт ажилтан, албан хаагчдыг амрааж, 2025 онд багтаан нөхөн ажиллуулах зохицуулалт хийхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад даалгасугай.	2025 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт ажилтан, албан хаагчдыг амрааж, 2025 онд багтаан нөхөн ажиллуулах зохицуулалт хийж, хэрэгжилтийг ханган ажилласан.	100

1	2	3	4	5	6
ЗГ-ЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ					
188	344	2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23	XXII.2.. “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов: 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах; 2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; 3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах.	1.shilen.gov.mn) сайтад 2025 оны тайлан мэдээг хугацаанд нь байршуулан, үнэлгээ хийлгэсэн. 2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байгууллагын Вэб хуудсыг холбосон; 3. Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг хангах үүднээс (shilen.gov.mn)-д байгууллагын 5-н албан хаагч мэдээлэл хийн ажиллаж байна.	100

ТАНИЛЦСАН:
ДАРГА

Д.ОТГОНБААТАР

ХЯНАСАН:
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.БАТТӨГС

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ТОГТООЛ, ШИЙДВЭР, ДОТООД АЖИЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Р.СОЛОНГО

